

Сургалтын орчны аюулгүй байдлын олон улсын туршлага ба Монгол Улсын бодлогын хэрэгжилт

Дэмбэрэлийн Цэвэлмаа*

Докторант, ts99172763@gmail.com

Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний батлан хамгаалахын их сургууль

Бадарчийн Сүхбат

Докторант, Badarchsuhbat1111@gmail.com

Монгол Улс, Улаанбаатар, Дотоод хэргийн их сургууль

Хураангуй

Энэхүү судалгаанд Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулиуд дахь сурах орчны аюулгүй байдлын асуудлыг олон улсын туршлагатай харьцуулан судаллаа. Судалгаанд үндэслэн хүүхдийн физик, дижитал, нийгэм-сэтгэлзүйн орчныг аюулгүй байлгах нь хөгжлийн үндсэн нөхцөл болохыг онцолсон. Түүнчлэн Монгол Улсад хэрэгжиж буй хууль, бодлого, стандартуудын хэрэгжилт хангалтгүй, хяналтгүй байгааг дүгнэлээ. Тухайлбал: Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн тоо улсын хэмжээний осол гэмтлийн статистик үзүүлэлтээр дээгүүр байр эзэлж байгаагаас үзэхэд аюулгүй байдлын хэрэгцээ хангагдаагүй нь илт байна. Иймд олон улсын сайн туршлагыг нутагшуулах, сургалтын орчны аюулгүй байдлын хяналт-шинжилгээг сайжруулах, хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагуудын уялдааг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Түлхүүр үг: Суралцах орчин, боловсролын бодлого, олон улсын туршлага, сургуулийн аюулгүй байдал, хүүхдийн хөгжлийн хэрэгцээ

Оршил

Аливаа нийгэм, улс үндэстэн оршин тогтнох, хөгжил дэвшлийн тулгуурын үндсэн суурь нь иргэдийн боловсролын чанар, хүртээмжтэй салшгүй холбоотой. Түүнчлэн зохих ёсны боловсролыг эзэмшихэд сургалтын орчин нэн чухал. Улс орны ирээдүйн үнэт капитал нь хүн бөгөөд бие даасан, бүрэн эрхт, нийгмийн харилцаанд өв тэгш оролцохуйц иргэнийг төлөвшүүлэх үйл явц нь төр улсын хувьд аюулгүй байдлын гол асуудал юм (ГБХЗХГ, 2019).

Нийгэм эдийн засгийн өөрчлөлтийн энэ үед хүүхдийн хүмүүжил төлөвшлийн асуудалд онцгойлон анхаарах шаардлагатай байна. Боловсролын тухай хуульд хүүхдийн хүмүүжил нь олон нийтийн үйл хэрэг гэж тусгах, хүүхдийн хүмүүжил төлөвшлийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд салбар хоорондын хамтын уялдаа болон

* Холбоо барих зохиогч

оролцогч талуудын байр суурийг тодорхой бий болгосон зүйл заалт шаардлагатай байна.

Сурах орчин гэж суралцагчийн мэдлэг, чадвар, дадал, хандлагыг хөгжүүлэхэд нөлөөлөх бүхий л нөхцөл, орчин тойрныг хэлнэ. Энэ нь физик, дижитал, нийгэм-сэтгэлзүйн гэсэн үндсэн гурван төрөлтэй.

1. Физик орчин

- Анги танхимын тохижилт, гэрэлтүүлэг, тав тух;
- Ном, сурах бичиг, самбар, техник хэрэгсэл;
- Аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан орчин.

2. Дижитал орчин

- Онлайн сургалтын платформ, цахим ном, хичээлийн бичлэг;
- Интернет, ухаалаг төхөөрөмж ашиглах боломж;
- Хиймэл оюун ухаан, интерактив программ хангамж.

3. Нийгэм-сэтгэлзүйн орчин

- Багш, сурагчдын харилцаа, хамтын ажиллагаа;
- Суралцах урам зориг өгөх, идэвхжүүлэх орчин;
- Алдаа гаргах боломжтой, аюулгүй, урамшуулдаг орчин.

Сурах орчин сайн байх нь суралцагчийн оюун санааны хөгжил, бүтээлч байдал, сонирхлыг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болдог (Цэдэвсүрэн, 2022). Тиймээс боловсролын байгууллагууд болон хувь хүмүүс сурах орчноо аль болох үр дүнтэй, эерэг болгох нь чухал байна. Сургалтын орчныг бүрдүүлэхдээ суралцагчдын өдөр тутмын амьдрал үйл ажиллагаатай холбон мэдлэг чадварт тулгуурласан, өдөр бүр олон төрлийн арга хэрэгсэл, хэрэглэн нийгмийн болон хувь хүний хэрэгцээг хангасан нас биеийн онцлогт нь тохирсон сургалт явуулж байж л үр дүнд хүрнэ (Валерика & Анжелеш, 2020).

Сургалтын орчны аюулгүй байдлыг хангах олон улсын туршлага, бодлогын хэрэгжилт

Орчин цагийн нийгмийн нөхцөлд хүүхдийн сургалтын орчны асуудал нь улс орнуудын боловсролын бодлогын гол чиглэл болон төлөвшиж байна. Эцэг эх, боловсролын байгууллагуудын өсвөр насныхны хөгжил, төлөвшилд тавих анхаарал, тэдэнтэй зөв, мэдрэмжтэй харилцах хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа нь төрийн бодлогоор зохицуулах шаардлагыг бий болгож байна.

Хүүхдийн хөгжил, хүмүүжил, төлөвшлийн талаар улс орнууд нийгмийн бодлогодоо хэрхэн тусгасан талаар судлаачдын судалгааны үр дүнгээс (ГБХЗХГ, 2019) тоймлон авч үзвэл:

1.БНФинУ-ын боловсролын систем нь хүүхдийн байгалиас заяасан хөгжил, сурах чадварыг дэмжих, сэтгэлзүйн ачаалал бага орчин бүрдүүлэх онцлогоороо ялгарч, дэлхийд хамгийн үр дүнтэй, шилдэг жишигт тооцогдож байна.

2. ОХУ нь хүүхдийн хөгжил, төлөвшлийг нийгмийн бодлогын тэргүүлэх чиглэл болгон хэрэгжүүлдэг. Үүний хүрээнд боловсрол, эрүүл мэнд, халамж, хамгаалал, ёс суртахуун, соёлын өвийг дэмжих олон төрлийн хөтөлбөр, хууль, баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлж байна. Энэ бодлогоор хүүхдийн амьдралын чанарыг сайжруулж, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхийн зэрэгцээ боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, нийгэмд бие даасан, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэхийг зорилго болгож байна.

Тус улс боловсролын бодлогоороо хүүхдийн танин мэдэхүй, оюун ухааны хөгжлийг тэргүүлэх чиглэл болгон дэмжиж, бүх хүүхдэд сургуульд суралцах тэгш боломжийг олгохыг зорьдог. Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхийн тулд урлаг, спорт, шинжлэх ухааны хөтөлбөрийг өргөжүүлэн хэрэгжүүлж, соёлын өвийг өвлүүлэхэд онцгойлон анхаарч иржээ. Хүүхдийн хөгжлийн үндэс нь эрүүл мэнд хэмээн үздэг тул үнэ төлбөргүй эмнэлгийн үйлчилгээ, вакцинжуулалт, урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг байнгын бодлого болгон хэрэгжүүлдэг. Үүнээс гадна эх, нярайн эрүүл мэндийн тусламжийг сайжруулах, нярайн эндэгдлийг бууруулах чиглэлээр бодит үр дүнд хүрч байна. Асран хамгаалалтын тогтолцоогоор дамжуулан өнчин, орхигдсон хүүхдийг улсын хамгаалалд авч, аюулгүй орчныг бүрдүүлэх, үрчлэлтийн тогтолцоог сайжруулахад тусгайлан анхаардаг.

Хүүхдийн нийгмийн оролцоо, ёс суртахуун, соёлын бодлогоор эх оронч үзлийг төлөвшүүлэх, нийгмийн амьдралд оролцуулах зарчмыг хэрэгжүүлдэг. Тухайлбал:

- **Эх оронч хүмүүжил** – Оросын түүх, соёл, ёс заншлыг хүүхдүүдэд сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор тусгай боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.
- **Гэр бүлийн үнэт зүйлсийг хамгаалах бодлого** – Гэр бүлийн харилцааг бэхжүүлэх, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, гэр бүлийн үнэ цэнийг ойлгуулахад анхаарч байна.
- **Нийгмийн оролцоог дэмжих** – Хүүхдийн оролцоотой олон нийтийн арга хэмжээ, сайн дурын хөдөлгөөнүүдийг дэмжиж, хүүхдүүдийг нийгэмд идэвхтэй байлгахыг түлхүү зорьдог.
- **Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх бодлого** – Хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тухай хуулийг шинэчилсэн. Цахим орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах хяналтын тогтолцоог сайжруулж, хүүхдийн эсрэг гэмт хэргийн тусгай мөрдөн шалгах нэгжүүдийг байгуулсан.

ОХУ нь хүүхдийн хөгжил, төлөвшлийг дэмжих олон төрлийн хууль, бодлого хэрэгжүүлдэг. Боловсрол, эрүүл мэнд, хамгаалал, ёс суртахуун, нийгмийн оролцоог онцгойлон дэмжиж, хүүхэд бүрийн эрхийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг

хэрэгжүүлдэг байна. Цаашид хүүхдийн хөгжил, төлөвшлийг илүү сайжруулахын тулд боловсролын чанар, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн хамгааллын системийг улам боловсронгуй болгох чиглэлд анхаарч ажиллаж байна (ХНХЯ, 2022).

3. БНХАУ нь хүүхдийн хөгжил, төлөвшлийг төрийн бодлого, хууль эрх зүйн тогтолцоогоор дэмжин хэрэгжүүлдэг. Хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүмүүжил, гэр бүлийн орчныг сайжруулах чиглэлээр олон бодлого явуулснаар тэдний эрхийг хамгаалж, хөгжлийг дэмжихэд үр дүнтэй арга хэмжээ болж байна. Тус улс хүүхдийг ирээдүйн хөгжлийн чухал хүчин зүйл гэж үздэг тул төрийн бодлого нь хүүхэд хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн асуудлыг гол цөмдөө авч, нийгмийн орчныг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнд онцгой анхаарал хандуулдаг.

Тус улсын боловсролын бодлого нь төрийн бодлогын тэргүүлэх чиглэлд оруулж, бүх хүүхдийг боловсрол эзэмших эрхээр хангах зорилготой. Боловсролын тогтолцоогоо илүү сайжруулах, орон нутгийн ялгааг арилгаж, чанартай, хүртээмжтэй болгох зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Бага, дунд боловсролыг үнэ төлбөргүй болгосон бөгөөд хүүхдийг есөн жилийн турш (бага болон дунд сургууль) заавал суралцуулах;
- Хөдөө орон нутаг дахь боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, алслагдсан бүс нутгийн хүүхдүүдийг чанартай боловсролоор хангахын тулд дотуур байр бүхий сургуулиуд байгуулж, багш нарын нөөцийг сайжруулах;
- Боловсролын салбарт дижитал технологийг өргөн ашиглаж, интернэтэд суурилсан сургалтын арга барилыг хөгжүүлэх;
- Сургууль, цэцэрлэгийн хоолны чанарт хатуу хяналт тавьж, шим тэжээлтэй хоол хүнсийг хямд үнээр хангах;
- Цахим орчны аюулгүй байдалд анхаарч, интернэт орчинд буруу мэдээлэлд автах, цахим гэмт хэргээс хамгаалах хууль, дүрэм журмуудыг баталж хэрэгжүүлсэн.

Ёс суртахуун, гэр бүлийн хүмүүжлээр хүүхдийн зан төлөв, харилцаа, ёс суртахууны төлөвшлийг хангах нь БНХАУ-ын нийгмийн бодлогын чухал хэсэг юм. Үүнд:

- Гэр бүлийн боловсролын тухай хуулийг 2021 онд баталж, эцэг эхчүүд хүүхдэдээ зөв хүмүүжил олгох үүрэг хүлээх болсон.
- Соёлын өвийг өвлүүлэх бодлогоор дамжуулан хүүхдүүдийг үндэсний соёл, зан заншилд сургах, эх оронч үзэл төлөвшүүлэх зорилготой сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Хүүхдийн хөгжил ба инновац бодлогыг хэрэгжүүлж хүүхдийг бүтээлч, шинийг санаачлагч иргэн болгон төлөвшүүлэхийн тулд шинжлэх ухаан, технологи, урлаг, спортын хөтөлбөрүүдийг өргөн хүрээнд авч үзэж байна. Мөн олон улсын хэмжээний олимпиад, уралдаануудыг дэмжиж, авьяастай хүүхдүүдийг тусгай хөтөлбөрт хамруулдаг.

БНХАУ нь хүүхдийн хөгжил, төлөвшлийг төрийн бодлогоороо өргөн хүрээнд дэмжиж, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, гэр бүлийн орчныг сайжруулахад ихээхэн анхаарал хандуулж байна. Хүүхдийн эрхийг хамгаалах, тэдний өсөлт, хөгжлийг хангах чиглэлээр олон төрлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлж, нийгмийн орчинд анхаарал хандуулан сайжруулдаг. Тус улс нь хүүхдийг ирээдүйн хөгжилд голлох үүрэг гүйцэтгэгч гэж үзэж, тэдний төлөвшилд чиглэсэн бодлогыг тасралтгүй шинэчилж, хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хүүхдийн хөгжил, боловсролын бодлого

Монгол Улс нь хүүхдийн хөгжил, төлөвшлийг төрийн бодлого, хууль эрх зүйн тогтолцоогоороо дэмжин хэрэгжүүлдэг. Хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүмүүжил, гэр бүлийн орчныг сайжруулах чиглэлээр олон бодлого хэрэгжүүлснээр тэдний эрхийг хангах, хөгжлийг дэмжих зорилготой. Хүүхдийг ирээдүйн хөгжлийн чухал хүчин зүйл гэж үздэг тул төрийн бодлогын гол цөмд хүүхэд хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн асуудлуудыг тусгаж, нийгмийн орчныг сайжруулахад анхаарал хандуулдаг.

Боловсролын бодлого: Монгол Улс бүх хүүхдийг боловсрол эзэмших эрхээр хангах зорилгоор тогтолцоог сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлдэг. Үүнд:

- Үнэгүй боловсролын систем;
- Хөдөө орон нутаг дахь боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Мэдээллийн технологид суурилсан боловсрол;
- Хүүхдийн хоол тэжээлийн хөтөлбөр;
- Хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомж;
- Өнчин, хараа хяналтгүй хүүхдийг хамгаалах хөтөлбөр;
- Цахим орчны аюулгүй байдал.

Монгол Улс хүүхдийн хөгжил, төлөвшлийг төрийн бодлогоороо өргөн хүрээнд дэмжиж, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, гэр бүлийн орчныг сайжруулахад ихээхэн анхаардаг. Хүүхдийн эрхийг хамгаалах, тэдний өсөлт, хөгжлийг хангах чиглэлээр олон төрлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлж, нийгмийн орчныг сайжруулсаар байна. Хүүхдийг ирээдүйн хөгжилд голлох үүрэг гүйцэтгэгч гэж үзэж, тэдний төлөвшилд чиглэсэн бодлогыг тасралтгүй шинэчилж, хэрэгжүүлдэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн батламжилсан “Төрөөс хүүхэд, залуучуудын талаар баримталсан чиглэл”-д “Хүүхдэд бага наснаас нь эхлэн амьдралын ухаан төлөвшүүлэх, хүүхдийн хүмүүжлийг эцэг эх голлон хариуцах талаар” (Монгол Улсын Засгийн газар, 2016) заажээ. Энэ нь хүүхдийг хэзээ, хаана, сониуч идэвхтэй бага насанд нь амьдралын арга ухаан зааж, сургах ёстойг оновчтой тодорхойлсон төрийн бодлого юм.

Орчин цагт амьдралын хэв шинжүүд өөрчлөгдөн гэр бүлийн олон төрлийн хэв маяг шинээр үүсэж байгаа нөхцөлд хүн ам цөөн манай орны хувьд гэр бүлийн

боловсролыг шинжлэх ухааны үндэслэлтэй, гэр бүлийн хэрэгцээнд нийцүүлэн олгох нь улс орны төдийгүй хүний хөгжлийн чухал асуудал юм гэж үзсэн. Хүүхдээ зөв хүн болгон хүмүүжүүлэх, төлөвшүүлэх, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах нь зөвхөн эцэг, эхийн ухамсар, амьдралын туршлагатай холбоотой бус, бүх эцэг, эхчүүдийн хуулиар хүлээсэн заавал биелүүлэх ёстой үүрэг юм (Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016).

Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага олон байдаг. Доорх хүснэгтэд зарим байгууллагын үүрэг, чиглэлийг харьцуулан үзүүлэв.

Хүснэгт 1. Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын үүрэг, чиглэлийг харьцуулсан судалгаа

№	Байгууллагын нэр	Төрөл	Үүрэг, чиглэл
1	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	Төрийн байгууллага	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудыг чиглүүлэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах.
2	НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF)	Олон улсын байгууллага	Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, эрүүл мэнд, боловсрол, хамгааллын чиглэлээр хөтөлбөрүүд хэрэгжүүлэх.
3	Хүүхдийг ивээх сан	Төрийн бус байгууллага	Боловсрол, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал болон хүмүүнлэгийн яаралтай тусламж үзүүлэх чиглэлээр ажиллах.
4	Хөөрхөн зүрх ТББ	Төрийн бус байгууллага	Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэх.
5	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	Төрийн бус байгууллага	Эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчдод үйлчилгээ үзүүлэх.
6	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо	Төрийн бус байгууллага	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үйлчилгээ үзүүлэх.

Эдгээр байгууллага нь хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийг дэмжих чиглэлээр тус тусын үүрэг, чиглэлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Боловсролын орчинд сурагчдын эсэн мэнд амьдрах эрхийг хангах, үүрэг хүлээх чиг үүрэг бүхий “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамгааллын тухай”, “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай” хуульд тодорхой тусгагдсан байдаг. Тиймээс дараах хүснэгтэд сурагчдын эсэн мэнд амьдрах эрхийг хангах үүрэгтэй байгууллага, албан тушаалтнуудын чиг үүргийг харьцуулсан хүснэгтээс харж болно.

Хүснэгт 2. Сурагчдын эсэн мэнд амьдрах эрхийг хангах үүрэгтэй байгууллага, албан тушаалтнуудын чиг үүргийг харьцуулсан

№	Хууль	Үүрэг хүлээгч	Гол чиг үүрэг
1	Боловсролын тухай хууль	Боловсролын байгууллага (сургууль, цэцэрлэг), багш, удирдлага	Сурагчдын аюулгүй орчинд суралцах нөхцөлийг бүрдүүлэх, аливаа хүчирхийллээс урьдчилан сэргийлэх
2	Хүүхдийн эрхийн тухай хууль	Эцэг, эх, асран хамгаалагч, төрийн байгууллага	Хүүхдийн амьд явах, хөгжих, хамгаалуулах эрхийг баталгаажуулах, аливаа эрсдэлээс сэргийлэх
3	Хүүхэд хамгааллын тухай хууль	Хүүхэд хамгааллын байгууллага, багш, эцэг эх	Хүүхдийн эрх зөрчигдөхөөс сэргийлэх, хамгаалах үйлчилгээ үзүүлэх
4	Эрүүл мэндийн тухай хууль	Эрүүл мэндийн байгууллага, эмч, сургуулийн эмч	Сурагчдын эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн тусламж үзүүлэх
5	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль	Цагдаагийн байгууллага, сургуулийн захиргаа	Сурагчдын гэмт хэргийн хохирогч болох, гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх
6	Хөдөлмөрийн тухай хууль	Ажил олгогч, боловсролын байгууллага	Хүүхдийг бохир, эрсдэлтэй хөдөлмөр эрхлэхээс хамгаалах

**Сургуулийн гадаад орчинд тавих аюулгүй байдлын шаардлага
(UNESCO, 2018) (түүвэрлэсэн)**

5.1 Эзэмшил газар

- 5.1.1 Сургуулийн эзэмшил газрын хил нь тухайн сургуулийн барилга байгууламжаас 30 м-ээс багагүй зайтай байна.
- 5.1.2 Сургуулийн эзэмшил газрыг хүрээлэн буй орчноос тусгаарласан хашаа нь 1.6 м-ээс доошгүй өндөр, хурц үзүүргүй, бат бөх бэхлэгээтэй, хүүхэд авирах, шургах, мал амьтан орох боломжгүй, шонг газарт 0.5 м-ээс доошгүй суулгана.

- 5.1.3 Эзэмшил газрын 25-аас доошгүй хувь нь ногоон байгууламж байна.
- 5.1.5 Эзэмшил газар нь бүрэн гэрэлтүүлэгтэй, галын аюулаас хамгаалсан байна.
- 5.1.6 Сургуулийн эзэмшил газрын тохижилтод хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, галын аюулгүй материал ашиглана.
- 5.1.7 Сургуулийн эзэмшил газрын талбайн өндрөөс биет унах эрсдэлтэй хэсэгт хамгаалалтын бүс тогтоож, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулна.

5.2. Барилгын аюулгүй байдал;

5.3. Биеийн тамирын талбай;

5.5. Аж ахуйн зориулалтын бүс;

5.6. Хог, хаягдлын цэг;

5.7. Хяналтын камер;

6. Сургуулийн дотоод орчинд тавих аюулгүй байдлын шаардлага

6.1 Барилгын аюулгүй байдал;

- 6.1.2 Аюул, аваар осол гарсан үед барилгаас гарах урсгал хөдөлгөөнийг харуулсан зураг, схем, аваарын гэрэл, дохио тэмдэглэгээг гарц бүрт байршуулна.
- 6.1.3 Гарцын тэмдэглэгээ харанхуйд гэрэлтүүлнэ.
- 6.1.4 Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын норм ба дүрэм БНБД 21-02-01-д заасны дагуу галын болон аюулгүй байдлын дохиоллын системтэй байна (UNESCO, 2018).

Сургуулийн насны хүүхдүүдийн осол гэмтэл, эндэгдлийн талаарх нарийвчилсан статистик 2024 оны байдлаар мэдээлэл хомс байна. Гэсэн хэдий ч Нийслэлийн эрүүл мэндийн газраас хийсэн судалгааны үр дүнгээс үзвэл:

- *Ахуй орчны осол гэмтэл:* 2024 оны байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 794 тохиолдол бүртгэгдсэн.
- *Усанд живэх осол:* Сүүлийн гурван жилийн хугацаанд 0-18 насны 133 хүүхэд усанд живж эндсэн. Үүнээс усанд санамсаргүй живэх нь 0-14 насны хүүхдийн гэнэтийн ослоос үүдэлтэй эндэгдлийн тэргүүлэх шалтгааны нэг болж байна.
- *Осол гэмтлийн нийт тохиолдол:* Өнгөрсөн онд осол гэмтлийн нийт 142 мянга гаруй тохиолдол бүртгэгдсэнээс, 42 мянга орчим нь 0-15 насны хүүхдэд тохиолдсон нь нийт осол гэмтлийн 29.2 хувийг эзэлж байна.

Осол гэмтлийн статистик мэдээллээс үзэхэд хүүхдүүдийн дунд осол гэмтэл, ялангуяа ахуйн орчинд болон усанд живэх зэрэг тохиолдол түгээмэл байгааг харуулж байна. (НЭМГ, 2024)

Мөн сургуулийн насны хүүхдүүд зам тээврийн осолд өртөх нь Монгол Улсад ноцтой асуудал хэвээр байна. Бага насны хүүхэд зам тээврийн осолд өртсөн 149 тохиолдол 2024 оны гуравдугаар сарын байдлаар бүртгэгдсэн гэж цагдаагийн байгууллагаас мэдээлжээ. Судалгааны дүнгээс харахад 2020–2024 оны хооронд нийт 4951 зам тээврийн осолд 5152 хүүхэд өртөж, 196 нь амь насаа алдсан нь хүүхдийн хөдөлгөөний аюулгүй байдлын асуудал нэн тулгамдсан хэмжээнд хүрснийг илтгэж байна. Энэ нь жил бүр дунджаар нэг ангийн сурагчидтай тэнцэх тооны хүүхэд амь насаа алдаж буйг харуулж байгаа бөгөөд бодлогын түвшинд хүүхдийн аюулгүй байдлын үнэлгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шинэчлэн боловсруулах шаардлагатайг нотолж байна.

Хүүхдүүд ихэвчлэн “гэр-сургууль-цэцэрлэг” гэсэн замаар хөдөлгөөнд оролцдог бөгөөд зам хөндлөн гарахдаа гарцтай хэсгээр гарахгүй байх, асран хамгаалагчгүй хөдөлгөөнд оролцох, ойртон ирж буй тээврийн хэрэгслийн урдуур гүйх зэрэг үйлдлээс болж осолд өртдөг аж. Хүүхдүүдийн зам тээврийн осолд өртөх эрсдэл нь хичээл эхлэх, тарах үе буюу 12:00-13:00; 16:00-17:00 цагт хамгийн өндөр. Мөн 11:00-17:00 цагийн хооронд дийлэнх осол бүртгэгдсэн нь цагдаагийн байгууллагын мэдээллээс харагдаж байна (ЦЕГ, 2024).

Хүүхдийн төлөвшилд нөлөөлөх орчны хүчин зүйлс:

Макро орчны хүчин зүйл улс орны үнэт зүйл, хэм хэмжээ, уламжлал, ёс заншил, нийгэм эдийн засгийн төлөвшлийн түвшин, хууль, дүрэм, институтууд дам нөлөө үзүүлдэг байна. Харин мезо орчны хүчин зүйлд бүлэг, амьдарч буй газар буюу орчин, олон нийтийн харилцааны сүлжээнүүд шууд ба дам байдлаар, микро орчны хүчин зүйлд гэр бүл, үе тэнгийнхэн, хамт олон, цэцэрлэг, сургууль шууд нөлөөлдөг. Эдгээр нь гэр бүл, хөрш, хамт олон, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цаг үеийн хөгжил, улс орны нийгэм, улс төрийн тогтолцоо, хууль эрх зүйн нөхцөл байдал, улс үндэстний соёлын өв уламжлал, нийгэм эдийн засгийн төлөвшлийн түвшин, боловсролын бодлого зэрэг бүгд хүүхдийн хүмүүжилтэй холбогддог ажээ.

- Макро орчны хүчин зүйлс болох улс орон, нийгэм, үнэт зүйл, хууль буюу уламжлал, соёлд хүүхэд амьдарч байдаг. Энэ нь тусдаа өвөрмөц ялгаатай гадаад түвшин юм. Макро хүчин зүйл бусад хүчин зүйлдээ нөлөөлж тусалдаг байна.
- Мезо орчны хүчин зүйлс нь үндэстэн ястнаас ялгагдах томоохон бүлгийн хүмүүсийн нийгэмшүүлэх нөхцөл (угсаатны бүлэг нь нийгэмшүүлэх хүчин зүйл гэж тооцогддог); тэдний амьдарч буй газар нутаг (бүс нутаг, хот, тосгон); олон нийтийн харилцааны олон янзын сүлжээ (радио, телевиз, кино театр гэх мэт) -д харьяалагдах замаар;
- Микро орчны хүчин зүйлсэд хүүхдэд шууд нөлөөлдөг буюу хамгийн ойр хүрээлэл: гэр бүл, үе тэнгийнхэн, цэцэрлэг, сургууль ордог байна.

Хүүхдийн хөгжил, төлөвшилд нөлөөлөх орчны хүчин зүйлс, тэдгээрийн нөлөөллийг тайлбарласан дээрх үзэл баримтлалуудаас авч үзвэл нийгмийн хүчин зүйлсийн нөлөөллийн дор бие хүн болон хүмүүжин, төлөвшдөг байна. Бие хүний

Зураг 1. Хэрэгцээний шатлал
А. Маслоу



хөгжлийг тайлбарласан нийгэм, хүмүүнлэгийн онолуудад ч энэ агуулга тодорхой тусгагдсан байна. Биологийн энэ хэрэгцээнээс гадна хүнд илүү нарийн хэрэгцээнүүд бий болдог. Харин тэдгээр хэрэгцээ нь биелэгдээд эхлэхэд дахиад түүнээс илүү нарийн хэрэгцээ шаардлагатай болж эхэлнэ. Энэ нь нэг ёсондоо хүний энгийн хэрэгцээнүүд нь зэрэглэлийн үе шатлалтай байдаг байна” (Maslow, 1943).

Маслоугийн хэрэгцээний шатлалын онол нь хүний хэрэгцээг таван шатлалд оруулан пирамид хэлбэрээр гаргасан байдаг.

Хамгийн доод шатны хэрэгцээг хангаснаар дээд талын шатлал руу ордог. Гэхдээ энэ нь заавал 100 хувь хангаж байж дээд талын хэрэгцээ рүү орно гэсэн үг биш юм. Шатлалыг доороос нь нэрлэвэл: физиологийн хэрэгцээ, аюулгүй байдлын хэрэгцээ, нийгмийн (хамт олон, хайр сэтгэлийн) хэрэгцээ, өөртөө итгэх итгэл тэгээд өөрийгөө олох хэрэгцээ. Эдгээр хэрэгцээ нь шаталсан бүтэцтэй бөгөөд доод түвшний хэрэгцээ хангагдсаны дараа дараагийн түвшний хэрэгцээгээ ухамсарлаж, түүнийг хангахыг эрмэлздэг гэж А. Маслоу үзсэн байдаг.

Хүүхдийн аюулгүй байдлын хэрэгцээ нь энэ шатлалын хоёр дахь түвшинд байрладаг. Физиологийн хэрэгцээ буюу амьд явахад зайлшгүй шаардлагатай хэрэгцээнүүд хангагдсаны дараа хүүхэд аюулгүй байдлын хэрэгцээгээ ухамсарлаж эхэлдэг. Энэ түвшний хэрэгцээ нь хүүхдийн бие мах бодийн болон сэтгэл зүйн аюулгүй байдал, эрүүл мэнд, ирээдүйдээ итгэлтэй байх, тогтвортой орчинд амьдрах зэрэгтэй холбоотой.

Хүүхдийн аюулгүй байдлын хэрэгцээг хангахын тулд дараах хүчин зүйлсийг анхаарах шаардлагатай:

- Гэр бүлийн орчин;
- Сургуулийн орчин;
- Нийгмийн орчин.

Психоаналитикийн онолын төлөөлөгчид дотоод зөрчил нь хувь хүн, бие хүн болж төлөвшихөд нөлөөлдөг нэг арга болохыг нотолсон. Зохих хүмүүжилтэй болсон хүүхэд хамгийн чухал туршлагыг дэс дарааллаар нь эзэмшихдээ боломжууд нь дараа дараалан нээгдэж өөрт нь анхаарал халамж тавьж, өөрийнх нь төлөө хариуцлага хүлээж байдаг хүмүүс, түүний амжилтыг хүлээж буй нийгэмтэй харилцан үйлчлэхэд

чиглэгддэгийг сайтар ойлгох нь чухал. Энэхүү харилцан үйлчлэл олон соёлын орчинд өөр өөр байдаг ч ямагт зохих хурдаар, зохих дэс дараалалтай явагдаж байж хүүхдийн төлөвшлийн ерөнхий шаардлага хангагдах боломжтой. Үүнээс үүдээд бие махбод нь тухайн хүнд болон нийгэмд ач холбогдолтой улам бүр өргөжин тэлэх түлхцүүдийн нөлөөгөөр бий болсон бэлэн байдал болон тэдгээрийг ухаарах, харилцан үйлчлэх замаар тодорхой үе шатыг дагаж хөгждөг хэмээн үзэж болно.

Эриксон өсвөр насны хүүхдүүд өөрийгөө өөртэйгөө адилтгасан дотоод адилтгалыг тогтмол мэдэрч, энэ мэдрэмжийг нь бусад хүмүүс хүлээн зөвшөөрч байна гэсэн итгэлтэй байх нь чухал. Ингэснээр энэ шатны эерэг тал болох өөрийн итгэл үнэмшил, дотоод ертөнц, чиг зорилгодоо үнэнч байдал үүснэ. Гэхдээ ийм итгэл үнэмшил нь бусадтай харилцах харилцаанд эргэх холбоогоор батлагдаж байх нь чухал.

Нэрд гарсан судлаач Абрахам Маслоу 1940-д оны үед хэрэгцээний таван шатлалын онолоо боловсруулжээ (Зураг 2).

Зураг 2. Абрахам Маслоу хэрэгцээний таван шатлалын онол

Физиологийн хэрэгцээ амьд явахад зайлшгүй чухал хооллох, хувцаслах, орон гэртэй байх, унтаж амрах гэх мэт амьдралын нэн чухал хэрэгцээ үүнд хамаарна. Эдгээр хэрэгцээ хүний биеийн физиологиос үүдэлтэй төрөлх шинжтэй.

Аюулгүй байх прээдүйдээ итгэлтэй байх хэрэгцээ нь орчны зүгээс бие махбод, сэтгэл зүйд учруулах аюул заналаас хамгаалах, физиологийн хэрэгцээ прээдүйд хангагдах итгэлтэй байх явдал юм. Ирээдүйд итгэлтэй байх хэрэгцээний илрэл бол даатгал, тэтгэвэр тэтгэмж баталгаатай, найдвартай ажлын байртай, ажиллах аятай нөхцөлөөр хангагдсан мэргэжил боловсролтой байх зэрэг болно.

Нийгмийн буюу оролцооны хэрэгцээ нь зөвхөн өөртөө эсвэл тодорхой нэг хүнд хамаатай гэж мэдрэгдэхээс гадна бусад хүн ёсоор үзэгдэж, дотночлогдож, хайрлагдаж, дэмжигдэхийг мэдрэх зэрэг харилцан үйлчлэлийн шаардлагыг агуулдаг.

Хүндлүүлэх хэрэгцээнд өөрийгөө хүндлэх хувийн амжилт, мэдлэг чадвар, хүрээлэлдээ хүндлүүлэх хүлээн зөвшөөрөх хэрэгцээ багтана.

Өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ нь өөртөө байгаа хүч бололцоог борлуулах, хувь хүний хувьд өсөн дэвжих явдал юм.

Дээрх бие хүний төлөвшлийн онолуудаас үзэхэд хүүхдийн төлөвшлийн эхэн үед нөлөөлөх үндсэн хүчин зүйлд эцэг эх, бусад насанд хүрсэн хүмүүсийн харилцаа, найз нөхөд, эд зүйлс, дараа нь төлөвшлийн таатай нөхцөл нь хайр халамж, хамтын ба бие

даасан үйл ажиллагааг зөв зохион байгуулах, зохион байгуулалтай сургалт, орчин, соёлын нөхцөлөөс хамаарч тодорхой түвшинд хөгждөг байна. Хүүхдийн төлөвшлийн үйл явцад голлох үүрэгтэй орчин нь соёлын үнэт зүйлсийн тогтолцоо, нийгмийн ахуй байдал (хүүхдийн хүрээлэл), хүмүүс (эцэг эх, үе тэнгийнхэн, найз нөхөд, багш сурган хүмүүжүүлэгч нар, хөршүүд), сургууль байна. Тиймээс хүүхдийг сурах орчны нөхцөл байдал ямар байгаа, сурах орчин нь үнэхээр тэдний аюулгүй байдалд нөлөөлж байгаа эсэхийг тодруулсны үндсэн дээр сурах орчны аюулгүй байдлыг хангах зорилт, үйл ажиллагаатай холбоотой хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломжтой болох юм.

Дүгнэлт

Сургуулийн сурах орчинд сурагчдын аюулгүй байдлыг хангах асуудал нь боловсролын чанарыг сайжруулахын үндэс суурь, цаашдын хөгжлийн гол шалгуур болдог. Энэхүү судалгаагаар олон улсын жишээ болон Монгол Улсад хэрэгжиж буй бодлого, зохицуулалтын түвшинд дүн шинжилгээ хийснээр хэд хэдэн дүгнэлтэд хүрсэн.

Юуны өмнө олон улсын тэргүүлэх жишээ болох Финлянд, Орос, Хятадын туршлагаас харахад хүүхдийн сурах орчныг зөвхөн физик аюулгүй байдал гэлтгүй, сэтгэлзүйн болон дижитал орчны аюулгүй байдлыг нэгэн адил чухалчилдаг. Тухайлбал: Финлянд нь сурагчийн сэтгэл зүйн тэнцвэрт байдал, бие даан хөгжих орчныг бүрдүүлэхэд төвлөрч, бага бүлгийн хичээл, ачаалал багатай хөтөлбөр, нийгмийн ажилтны дэмжлэг зэргээр онцгойрч байна. Орос нь хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, соёлын өв, ёс суртахууны хүмүүжлийг хослуулсан цогц хөтөлбөрийг бодлогын түвшинд хэрэгжүүлдэг бол Хятад нь сургалтын чанартай тэнцүү анхаарал хандуулж, цахим орчны аюулгүй байдал, мэдээллийн технологийн хүртээмж, гэр бүлийн хүмүүжлийн тухай хуулиар дамжуулан хүүхдийн аюулгүй байдалд бодитой дэмжлэг үзүүлдэг.

Монгол Улсын хувьд хүүхдийн эрхийг хамгаалах, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд сүүлийн жилүүдэд тодорхой ахиц гарсан. Тухайлбал: Ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй болгож, үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нь хүүхдийн суурь хэрэгцээг хангах эерэг алхам юм. Мөн Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Боловсролын тухай хууль зэрэг эрх зүйн баримт бичгүүдэд хүүхдийн сурах орчны аюулгүй байдлыг хангах чиг үүргийг тодорхой заасан. Гэвч бодлогын хэрэгжилт, хяналт-шинжилгээ сул, байгууллагууд хоорондын уялдаа муу, нөөц бололцоо хязгаарлагдмал байдал нь аюулгүй орчныг бүрдүүлэхэд саад болж байна.

Статистик мэдээллээр хүүхдийн осол гэмтэл, зам тээврийн осол, сэтгэлзүйн дарамт, цахим орчны эрсдэл өндөр хэвээр байгаа нь сургалтын орчны аюулгүй байдлын асуудал амьдрал дээр төдийлөн хангагдаж чадахгүй байгааг харуулж байна. Иймд Монгол Улсад дараах гурван үндсэн чиглэлд анхаарч, олон улсын туршлагыг нутагшуулах шаардлагатай байна. Үүнд:

1. Бодлогын хэрэгжилтийг сайжруулах – Хууль тогтоомжийг амьдралд бүрэн хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох;
2. Орчны цогц шинэчлэл хийх – Сургуулийн физик орчны аюулгүй байдлаас гадна багш, сурагчийн харилцаа, сэтгэлзүйн дэмжлэгийг хослуулсан уур амьсгалыг бүрдүүлэх;
3. Салбар хоорондын уялдааг нэмэгдүүлэх – Боловсрол, эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, замын хөдөлгөөний байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх.

Эндээс дүгнэхэд сурагчийн аюулгүй орчинд сурч, хөгжих эрхийг бүрэн хангах нь боловсролын үр дүнтэй салшгүй холбоотой. Монгол Улс энэ чиглэлд олон улсын шилдэг туршлагыг судлан, үндэсний онцлогт нийцүүлэн боловсронгуй бодлого хэрэгжүүлэх нь чухал байна.

Эх сурвалжийн жагсаалт

Хүүхдийн эрхийн тухай хууль. (2016). Хүүхдийн эрхийн тухай хууль, 9, 10 дугаар зүйл. Улаанбаатар.

Maslow, A. (1943). In Адамын хэрэгцээний төслийн онол (р. 375).

UNESCO. (2018). Сургалтын орчны стандарт, ISO 45001 - Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт. UNESCO.

Валерика, & Анжелеш. (2020). Суралцагчдын хандлагад нөлөөлөх хүчин зүйлийг судлах нь диссертаци. Улаанбаатар.

ГБХЗХГ. (2019). Хүүхдийн хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж болох хүчин зүйлийн судалгаа. Улаанбаатар .

ГБХЗХГ. (2019). Хүүхдийн хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж болох хүчин зүйлийн судалгаа. Улаанбаатар.

Монгол Улсын засгийн газар. (2016). Төрөөс хүүхэд, залуучуудын талаар баримталсан чиглэл. Улаанбаатар: Монгол Улсын засгийн газар.

НЭМГ. (2024). Нийслэлийн эрүүл мэндийн статистик мэдээлэл. Улаанбаатар: НЭМГ.

ХНХЯ. (2022). Олон улсын хүүхдийн Найрамдал-II цогцолборын техник эдийн засгийн үндэслэл. Улаанбаатар: ХНХЯ.

ЦЕГ. (2024). Хүүхдийн зам тээврийн осолд өртсөн статистик мэдээлэл. Улаанбаатар: ЦЕГ.

Цэдэвсүрэн, Н. (2022). Сурах, сурах орчны судалгаа. Улаанбаатар. Retrieved from <https://v3.esan.mn/p/mergejliin-nom/bolovsrol/surah-surgah-orchny-sudalgaa>

Ensuring Safe Educational Environments: International Experience and Policy Implementation in Mongolia

Tsevelmaa Demberel*

Ph.D., candidate, ts99172763@gmail.com
Mongolian National Defense University, Ulaanbaatar, Mongolia

Sukhbat Badarch

Ph.D., candidate, Badarchsuhbat1111@gmail.com
University of Internal Affairs, Mongolia,
Ulaanbaatar, Mongolia

Abstract

This study investigates safety concerns in Mongolia's general education school settings in comparison to global standards. The research highlights the importance of creating secure physical, digital, and socio-psychological environments for children as a crucial factor for their development. However, the study notes that the enforcement and oversight of laws, policies, and regulations in Mongolia, are lacking. The high incidence of accidents and injuries, particularly children impacted by traffic accidents, underscores the urgent need for improved safety measures. Therefore, the study recommends adopting international best practices, enhancing monitoring of educational safety, and strengthening collaboration among child protection agencies.

Keywords: Learning environment, Education policy, International practices, School safety, Child developmental needs

* Corresponding author

Received: September 17, 2025 | Accepted: September 24, 2025 | Published online: October 13, 2025



© The Author(s) 2025
<http://creativecommons.org/licenses/by/4.0/>